


БАТЛАВ:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА Г.ЧИНЗОРИГ



/гарын үсэг/



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар

“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ МОНИТОРИНГ ХИЙХ”
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Тендерийн дугаар: **ХХЗХ/202401037**

Багцын дугаар: **Багц 1** - Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөлтэй телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн
хөтөлбөрт байнгын хяналт мониторинг хийх

2024 он

АГУУЛГА

1. Үндэслэл
2. Зорилго
3. Хяналт, мониторингийн хамрах хүрээ
4. Хяналт, мониторинг хийх үзүүлэлт
5. Хяналт, мониторинг хийхэд баримтлах зарчим
6. Тайлан ирүүлэх хугацаа, хэлбэр
7. Тайлан ирүүлэх удирдамж
8. Гүйцэтгэгчид тавигдах шалгуур шаардлага
9. Хэрэгжүүлэх арга зүй ба ажлын хуваарь
10. Мониторингийн тайлангийн ерөнхий бүтэц, загвар

1. ҮНДЭСЛЭЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2011 оноос хойш хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөгжлийг дэмжих, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд хүүхэд, үзэгч олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, зах зээлийн шударга өрсөлдөлдөөний таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөр, зар сурталчилгаанд тус хорооноос батлан гаргасан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-т заасан хэмжигдэхүйц тодорхой үзүүлэлтүүдээр хяналт, мониторинг хийж ирсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдаж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан эрх, чиг үүргийн хүрээнд Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам батлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт, мониторинг хийж, хяналт мониторингийн дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр мэдэгдэх, хяналт мониторингийн дүнг олон нийтэд мэдээлж ажиллах шаардлагатай байна.

Тус хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлага болон хуульд заасан дээрх журам, нөхцөл шаардлагуудын хэрэгжилтэнд байнгын хяналт, мониторинг хийж хяналт, мониторингийн дүн, мэдээнд үндэслэн холбогдох тайлан мэдээг гаргах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах юм.

2. ЗОРИЛГО

Энэхүү ХХЗХ/202401037 тоот үйлчилгээний тендерийн “Багц-1” ажлын даалгаврын гол зорилго нь ХХЗХ-оос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, 30.1.8-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасан шаардлага болон тус хуульд заасан Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй нийт телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийхэд (цаашид “хяналт, мониторинг хийх” гэх) оршино.

Телевизүүдийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийхдээ дээрх хууль тогтоомжуудын холбогдох заалтуудыг хангаж ажилласан эсэх талаарх дүнг сар бүр нэгтгэн гаргах, нээлттэй байршуулах, сар бүр, улирал, жилийн нэгдсэн дүнгээр холбогдох харьцуулалтыг хийх, судалгаа гаргах, нөхцөл шаардлага хангаагүй үзүүлэлтийг ил тод байршуулах, зөрчлийг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллах юм.

Телевизүүдийн бэлтгэн нэвтрүүлж байгаа хөтөлбөрт хийгдэж байгаа байнгын хяналт, мониторингийн дүн мэдээнд үндэслэн шаардлагатай судалгаа, мэдээллийг мөн улирал, жилээр гаргаж ажиллах бөгөөд үүний үр дүнд телевизийн зах зээлийн мэдээлэл, зар сурталчилгааны зах зээлийн судалгаа, статистик тоон мэдээлэл бүрдэх, өргөн нэвтрүүлгийн талаарх бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, боловсронгуй болгох улмаар цаашдын чиг хандлагыг тодорхойлох судалгааны суурь мэдээлэл бүхий бааз бий болгох ач холбогдолтой юм.

Түүнчлэн илэрсэн зөрчил дутагдал, нөхцөл шаардлагад заасан чиглэлээр гомдол маргаан үүссэн тохиолдолд ашиглах эфирийн бичлэг, тайлан протоколын архив, сан үүсэх боломж бүрдэх болно.

3. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

3.1 Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн - 18, МҮОНТ-ийн - 5, арилжааны - 54, орон нутгийн Монгол улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй - 3 телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийнэ. Шаардлагатай тохиолдолд төлбөртэй 21 телевизийн хөтөлбөрт мониторинг хийнэ.

3.1.1 Хяналт, мониторингд хамрагдах телевизүүдийн тоо (2024 оны 01 сарын 18 өдөр)

Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Мониторингийн гэрээнд
МҮОНТ	5	5
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18	18
Арилжааны телевиз	54	54
Орон нутгийн Монгол Улсад хамрах хүрээтэй ӨНТВ	3	3
Нийт	80	80 (Гэрээнд 75+- 5)
Төлбөртэй телевиз (төлбөрт, төлбөрт үзэлт)	21	Шаардлагатай тохиолдолд мониторингд хамруулж болно

Дээрх хүснэгтэд заасан өргөн нэвтрүүлгийн болон арилжааны 80 телевизүүдээс 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар идэвхгүй (үйл ажиллагаа эхлээгүй 4 ТВ, түр зогссон 1 ТВ) байна. Шаардлагатай тохиолдолд Улаанбаатар хотын төлбөртэй телевизүүдээс сонгож мониторингд хамруулна.

Хяналт, мониторингийн хугацаанд ОСДҮЭ-ийн сүлжээнд холбогдож хөтөлбөр дамжуулж эхэлсэн телевизийг тухай бүр нэмнэ.

- 3.2 Хяналт, мониторингийг өглөөний 06.00 цагаас шөнийн 01:00 цаг хүртэлх эфирийн цагаар хийнэ. Шаардлагатай нөхцөлд хяналт, мониторингийн цагийг 1-2 цагаас илүүгүйгээр сунгаж болно.
- 3.3 Захиалагчийн зүгээс хяналт, мониторингд хамрагдах телевизүүдийн жагсаалт, шаардагдах мэдээллийг шалгарсан оролцогчид гаргаж өгнө.
- 3.4 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын хугацаанд өөрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс тухайн маргаантай холбоотой телевизүүдийн хөтөлбөрийн бичлэг авах, холбогдох мэдээллийг гаргуулж авах эрхтэй.
- 3.5 Захиалагч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Ажлын даалгаварт заасан хяналтын үзүүлэлтээр гарсан тайланг шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагаатай холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж болно.

4. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөтөлбөрт тавигдах үндсэн шаардлага

- 4.1 Телевизийн хөтөлбөрийн үндсэн, дэлгэрэнгүй протокол гаргах, үүнд: *телевизийн нэр, огноо, эфирт гарсан нэвтрүүлгийн нэр, нэвтрүүлгийн эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, төрөл, жанр, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээ, бичгэн болон хадмал тайлбартай эсэх гэх мэт мэдээллүүдийг агуулсан дэлгэрэнгүй хэлбэртэй байхаар гаргах;*
- 4.2 Хөтөлбөрт эзлэх үндэсний бүтээл, нэвтрүүлгийн (Өргөн нэвтрүүлгийн телевизийн 7 хоногийн нийт хөтөлбөрийн 60%-иас доошгүй, арилжааны телевизийн 7 хоногийн нийт хөтөлбөрийн 50%-иас доошгүй байх) шаардлага хангасан байдал;
- 4.3 Телевизийн хөтөлбөрт эзлэх өөрийн бүтээлийн хувь хэмжээ нь (7 хоногийн хөтөлбөрийн 30%-иас доошгүй нь байх) шаардлагыг хангасан эсэх;
- 4.4 Телевизээр нэвтрүүлэх гадаадын аль нэг улсын кино нь нэг сарын хөтөлбөрт нэвтрүүлсэн нийт гадаад киноны шаардлагыг (нийт киноны 50%-иас хэтрэхгүй байх шаардлага) хангаж байгаа эсэх;
- 4.5 Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийн жилд нэвтрүүлсэн түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нь 200 цагаас багагүй байх шаардлагыг, үүний 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байх шаардлагыг хангаж байгаа эсэх; (эдгээр нэвтрүүлгийн нийт цагийг гаргах)
- 4.6 Өргөн нэвтрүүлгийн телевизийн жилд нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлэг 180 цагаас багагүй байх шаардлагыг хангаж байгаа эсэх; (танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт цагийг гаргах)
- 4.7 Өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 130 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлэх ба нийт цагийн 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байх шаардлагыг хангасан эсэх; (тухайн нэвтрүүлгийн нийт цагийг гаргах)
- 4.8 Өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 90 цагаас багагүй хугацааны 3+ насны ангилалтай балчир хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлэх үргэлжлэх хугацаа нь 15 минутаас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан эсэх; (тухайн нэвтрүүлгийн нийт цагийг гаргах)
- 4.9 Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизээр дамжуулсан цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах заалтын хэрэгжилтийг хангаж байгаа эсэх;
 - 4.9.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз нь Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын 3.10.2-т заасан хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байх шаардлага хангасан эсэх; *(Жич: Арилжааны телевизийн хувьд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүрэг хүлээгээгүй тул, МУ-д хамрах хүрээтэй арилжааны телевизийн хувьд: хэрэв хөтөлбөрт нь хүүхдэд зориулсан нэвтрүүлэгтэй, тэр нь дохионы хэлтэй гарсан бол тэмдэглэнэ.)*
- 4.10 Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээтэй буюу 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг 06:00-22:00-ийн хооронд нэвтрүүлэх, давтан дамжуулж байгаа эсэх;
 - Илт зохисгүй агуулга, контент бүхий дүрс бичлэг, кино, нэвтрүүлэг, контентийг бүртгэлжүүлэн тайланд тусгаж ирүүлэх; Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийг удирдамж болгоно.

- 4.11 Теле худалдааны төрөлжсөн чиглэлийн телевизийн хөтөлбөр нь теле худалдааны чиглэлээр дагнасан байх заалтын хэрэгжилтийг хангаж байгаа эсэх;

Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд тавигдах үндсэн шаардлага

- 4.12 Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизээр нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, үүнд: “1 цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх” заалтыг хангасан байдал;
- 4.13 Оргил цагаар (18:00-23:00) нэвтрүүлэх зар сурталчилгааны 80 хувиас доошгүй нь Монголд бүтээсэн байх заалтыг хангасан байдал;
- 4.14 Нэг блокны үргэлжлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байх заалтыг хангасан эсэх;
- 4.15 Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- 4.16 Телевизээр хоногт нэвтрүүлсэн арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15%-иас илүүгүй байх заалтыг хангасан эсэх; *(Хонжворт сугалааг арилжаа сурталчилгааны нэвтрүүлэгт тооцож, хонжворт сугалааны нэвтрүүлгийн цаг, хувийг харуулсан байдлаар ирүүлэх)*
- 4.17 Мэдээний дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- 4.18 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн багц хооронд 2-оос ихгүй зар сурталчилгааны блок нэвтрүүлэхгүй байх шаардлагыг хангасах эсэх;
- 4.19 Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй аливаа нэвтрүүлэг, киноны үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр, урсдаг зар байдлаар дэлгэц дээр гаргаж байгаа эсэх;
- 4.20 МҮОНТ-ийн хувьд арилжааны зар сурталчилгаа нэвтрүүлсэн байдал, өдрийн хөтөлбөрийн 2 хувиас хэтэрсэн эсэх;
- 4.21 "Телевиз нь эд мөнгөний хонжворт сугалаа болон бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр худалдан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй."
- 4.22 Балчир насны буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх заалтын хэрэгжилтийг хангасан эсэх;
- 4.23 Бага насны буюу 6+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа нь 30 минутын хугацаанд 5 (таван) минутаас илүүгүй байх заалтыг хэрэгжилтийг хангасан эсэх;
- 4.24 Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно заалтын хэрэгжилт;
- 4.25 Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизээр зар сурталчилгаа, бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, нэвтрүүлсэн эсэх;

Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд тавигдах бусад шаардлага

Дараах үзүүлэлтүүдийг сар бүрийн нэгдсэн тайлангаас харах боломжтой, улирлын дүн мэдээг үзүүлэлт тус бүрээр нэгтгэж гаргах.

- 4.26 Ивээн тэтгэгчтэй нэвтрүүлгийн бүртгэлийг хийх, ивээн тэтгэгчийг тухайн нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд болон нэвтрүүлгийн явцад дурдсан эсэх;
- 4.27 Бүтээгдэхүүн байршуулалттай нэвтрүүлгийн бүртгэл;
- 4.28 Төлбөртэй эсхүл захиалгатай нэвтрүүлгийн бүртгэл; “Төлбөртэй нэвтрүүлэг” эсхүл “Захиалгат нэвтрүүлэг” гэсэн тэмдэглэгээтэй эсэх;

- 4.29 Телевизийн нэвтрүүлж буй зар сурталчилгаанд эзлэх нийгмийн зар сурталчилгааны хугацаа;
- 4.30 Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран үзэгчдээс чат, мессеж хэлбэрээр ирүүлсэн үгэн зар, нийгмийн сүлжээгээр дамжуулж байгаа зар сурталчилгааг дэлгэц дээр харуулах байдлаар нэвтрүүлэхгүй.
- 4.31 Хүүхдийн нэвтрүүлэг дундуур хүүхдийн сэтгэхүй болон бие махбодод сөргөөр нөлөөлөх дараах хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх
- Бүх төрлийн хийжүүлсэн ундаа;
 - Энергийн болон спортын ундаа;
 - Бүх төрлийн чанадаг болон дэвтээдэг бэлэн гоймон

Төлбөртэй телевизийг сонголтгоор хянуулах тохиолдолд

- 4.32 Төлбөртэй телевизийн хөтөлбөр нь төрөлжсөн чиглэлээр дагнасан эсэх;
- 4.33 Төлбөртэй сувгийн зөвшөөрөлтэй телевизээр зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- 4.34 Төлбөртэй телевизээр бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлтээс бусад зар сурталчилгаа, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, теле худалдааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх;

Бусад шаардлага

- 4.35 ОСДҮЭ-ийн үндсэн багцын сувгийн бүртгэл, (гадаад сувгийн хувьд: сувгийн нэр, улсын нэр, дамжуулагдаж байгаа хэл, сувгийн хөтөлбөрийн төрөл жанр;(шаардлагатай тохиолдолд мэдээлэл гаргуулж авах)
- 4.36 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангасан байх заалтын хэрэгжилтийг хангасан байх заалтын хэрэгжилтийн талаарх мэдээ тайлан;
- 4.37 Телевизийн нэр, үйлчилгээний нэрийг өөрчилсөн тохиолдолд энэ талаар Захиалагч байгууллагад шуурхай мэдэгдэж тодруулга авна. Долоо хоногт 1 удаа хайлт хийж жагсаалтад шинээр нэмэгдсэн болон хасагдсан телевиз, сувгийн талаарх мэдээллийг Захиалагч байгууллагад шуурхай гаргаж өгнө;
- 4.38 Захиалагчаас шаардсаны дагуу холбогдох эфирийн дүрс, бичлэг, хөтөлбөрийн баримт, нотолгоог шуурхай гаргаж ирүүлнэ;
- 4.39 Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээлэл, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх;

5. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Хяналт, мониторинг хийх үзүүлэлтүүд нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг хууль, холбогдох баримт бичгүүдэд үндэслэнэ. Хяналт, мониторинг хийхдээ дараах зарчмыг удирдлага болгон баримтлана. Тухайлбал:

5.1 Үндэсний бүтээл, нэвтрүүлгийн хувийг тооцохдоо:

- Тив, дэлхийн хэмжээний урлаг, спортын арга хэмжээг албан ёсны эрхтэйгээр монгол хэл дээр, хөтөлгөч тайлбарлагчтайгаар дамжуулж байгаа нэвтрүүлэг;
- Нэвтрүүлгийн давталт.
- Үндэсний бүтээлд реклам, арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг хамаарахгүй.

- Үндэсний бүтээлд Монгол Улсын иргэн, эсхүл тухайн бүтээлийн уран бүтээлчдийн багийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн бүтээсэн бүтээлийг тооцно.
 - Цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн цагийг үндэсний бүтээл, нэвтрүүлгийн хувь хэмжээнд оруулж тооцно.
- 5.2 Өөрийн бүтээлийн хувь хэмжээг тооцоход:
- Өөрийн бүтээлд арилжааны зар сурталчилгаа (реклам), арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг хамаарахгүй.
- 5.3 Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийн жилд нэвтрүүлсэн түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нь 200 цагаас багагүй байх шаардлагыг, үүний 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байх шаардлагыг хангаж байгаа эсэх:
- Монгол үндэстний эрх ашиг, соёл, эх хэл, зан заншил, ахуй амьдралыг сурталчилсан, таниулсан монгол хэл дээр орчуулсан ярилцлага, нэвтрүүлэг, баримтат киног оруулан тооцно.
- 5.4 Өргөн нэвтрүүлгийн телевизийн жилд нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлэг 180 цагаас багагүй байх шаардлагыг хангаж байгаа эсэх:
- Танин мэдэхүйн нэвтрүүлэг гэдэгт шинжлэх ухаан, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, урлаг, соёлын өвийг тайлбарлан таниулсан баримтат бүтээл, нэвтрүүлгийг ойлгоно.
- 5.5 Өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 90 цагаас багагүй хугацааны 3+ насны ангилалтай балчир хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлэх үргэлжлэх хугацаа нь 15 минутаас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан эсэх:
- 3+ насны ангилалтай балчир хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь үндэсний бүтээл байна.
 - Телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх кино, нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлнэ.
 - Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийг оройн 21:00 цагаас хойш нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй.
 - Насны ангилал тогтоогоогүй, тэмдэг тэмдэглэгээ ашиглаагүй нэвтрүүлсэн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг мөн хүүхдийн нэвтрүүлгийн цагт оруулж тооцно.
- 5.6 Өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 130 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлэх ба нийт цагийн 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байна.
- Телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх кино, нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлнэ.
 - Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийг оройн 21:00 цагаас хойш нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй.
 - Насны ангилал тогтоогоогүй, тэмдэг тэмдэглэгээ ашиглаагүй нэвтрүүлсэн хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг мөн хүүхдийн нэвтрүүлгийн цагт оруулж тооцно.
- 5.7 Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно заалтын хэрэгжилт;
- Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур холбогдох эрх бүхий байгууллагын гаргасан зөвлөмжийн дагуу чихэр, давс, транс болон

- ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүн сурталчлахгүй, аливаа бараа, бүтээгдэхүүн байршуулахгүй.
- 5.8 Хүүхдийн чиглэлээр дагнасан төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизээр 18+ насны ангилалтай нэвтрүүлэг, кино нэвтрүүлэхгүй.
- Зар сурталчилгааг бусад нэвтрүүлэг, ХХЗХ-оос батлан гаргасан “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм”-ийг баримтлана.
- 5.9 Зар сурталчилгааны хугацааг тооцоход:
- хөтөлбөрөөс ойлгомжтой байдлаар ялгасан байх ба зар сурталчилгааны блокийн эхлэл, төгсгөлийг тогтсон үг хэллэг, богино ая, дуу, дүрс ашиглан үзэгчид ойлгомжтой байдлаар илэрхийлнэ.
 - Гамшгаас хамгаалах тухай хууль, журам, зааварт тусгайлан заасан гамшгийн аюулын дохиог гамшгийн зарлан мэдээллээс бусад зорилгоор зар сурталчилгаанд ашиглахгүй.
- 5.10 Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа (реклам) нь 15 минутаас хэтрэхгүй байх заалтыг тооцохдоо:
- Нэг цаг гэдэгт тухайн цаг эхлэх минутын 00 секундээс дуусах сүүлийн минутын 59 секунд хүртэлх хугацааг ойлгоно.
 - Нэг цагт нэвтрүүлэх зар сурталчилгааны хязгаарлалтанд тухайн цагт нэвтрүүлсэн зар сурталчилгааны давталт хамаарна.
 - Үгэн болон урсдаг зарын зар сурталчилгааны хугацааны хязгаарлалтад оруулж тооцох ба зарыг Монгол хэлний хэм хэмжээ, зөв бичих дүрэм, зүй тогтолд нийцүүлэн урьдчилан бэлтгэж, хөтөлбөрийн хуваарьт оруулж зарын цагаар нэвтрүүлнэ.
 - Телевизийн өөрийн хөтөлбөр, нэвтрүүлгийн танилцуулга, сурталчилгаа, эрх бүхий байгууллагын гаргасан гамшгийн зарлан мэдээлэл, заавар, зөвлөмж зэргийг зар сурталчилгааны хязгаарлалтанд оруулж тооцохгүй.
 - Радио, телевизийн нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хугацааг Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журамд заасан зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.
- 5.11 Телевизээр хоногт нэвтрүүлсэн арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15%-иас илүүгүй байх заалтыг хангасан эсэх заалтыг тооцохдоо:
- Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг гэдэгт бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний сурталчилгааг мэдээллээр баяжуулж, онцлогийг тодотгож, ач холбогдол, зааврын талаар дэлгэрүүлж мэдээлэх хэлбэрээр бэлтгэсэн нэвтрүүлгийг ойлгоно.
 - Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэгт төрөл бүрийн хонжворт сугалааг оруулж тооцох (тайланд хонжворт сугалаа зохион байгуулж байгаа компани, үргэлжилсэн хугацаа зэрэг мэдээллийг оруулсан байна)
- 5.12 Мэдээний дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх заалтыг тооцохдоо:
- Мэдээг зар сурталчилгаа, төлбөрт болон захиалгат мэдээ, нэвтрүүлгээс ойлгомжтой байдлаар ялгасан байна.
 - Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн багц хооронд 2-оос ихгүй зар сурталчилгааны блок нэвтрүүлж болно.
- 5.13 Зар сурталчилгааны цагаас бусад үед нэвтрүүлж буй аливаа нэвтрүүлэг, киноны үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр, урсдаг зар байдлаар дэлгэц дээр давхардуулан гаргахгүй байна.

- Баннер гэдэгт телевизийн дэлгэцийн буланд гарах хөдөлгөөнтэй эсвэл хөдөлгөөнгүй график дүрс, текстийг хамааруулж ойлгоно.

5.14 Теле худалдааны төрөлжсөн телевизийн тухайд:

- Теле худалдааны нэвтрүүлэг гэдэгт - төрөл бүрийн бараа, бүтээгдэхүүнийг студид байрлуулан биетээр сурталчлан таниулж, хэрэглэх заавар, зөвлөгөөг тайлбарлан үзүүлж үзэгчдээс захиалга авч, хүргэх зорилгоор дэлгэрүүлэн мэдээлэх хэлбэрээр бэлтгэсэн сурталчилгааны нэвтрүүлгийг ойлгоно. Тухайн бараа, бүтээгдэхүүний онцлог, шинжээс хамаарч танилцуулгыг студид бус өөр орчин, нөхцөлд бэлтгэсэн байж болно.
- Теле худалдааны нэвтрүүлгийг зөвхөн теле худалдааны чиглэлээр дагнасан төрөлжсөн арилжааны телевизээр нэвтрүүлнэ.
- Теле худалдааны нэвтрүүлэг дундуур тухайн сурталчилж байгаа бараа, бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт, үнэ, үнийн хямдрал, захиалга авах утас зэрэг мэдээллийг агуулсан баннер гаргаж болно.
- Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизээр зөвхөн теле худалдааны нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх бөгөөд зар сурталчилгаа, бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, нэвтрүүлэхгүй.

5.15 Төлбөртэй телевизийн тухайд:

- Төлбөртэй телевизийн хөтөлбөр нь төрөлжсөн чиглэлээр дагнасан байх;
- Төлбөртэй сувгийн зөвшөөрөлтэй телевизээр зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй
- Төлбөртэй телевизээр бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлтээс бусад зар сурталчилгаа, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, теле худалдааны нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.

5.16 Баннер, урсдаг зар, тв тохиролцоо, тв худалдаа:

- Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй аливаа нэвтрүүлэг, киноны үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр, урсдаг зар байдлаар дэлгэц дээр давхардуулан гаргахгүй байна.
- Телевизээр нэвтрүүлэх урлаг, спортын тоглолт, тэмцээн, уралдааны дамжуулалтын үеэр тухайн арга хэмжээг ивээн тэтгэгчийн баннерыг (*нэр, лого, дүрс, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, барааны тэмдэг*) үзэгчдэд саад учруулалгүйгээр, богино хугацаанд, зохистой хэмжээнд гаргаж болно.
- Телевиз нь бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр сурталчлан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.

5.17 Тусгай дугаар, чат мессеж:

- Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран үзэгчдээс чат, мессеж хэлбэрээр ирүүлсэн үгэн зар, нийгмийн сүлжээгээр дамжуулж байгаа зар сурталчилгааг дэлгэц дээр харуулах байдлаар нэвтрүүлэхгүй.

6. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУГАЦАА, ХЭЛБЭР

- 6.1 Сар бүрийн мониторингийн дүнг дараа сарын 10-ны өдрийн дотор электрон хэлбэрээр болон CD дээр буулган ирүүлнэ.

- 6.2 Мониторингийн тайланг нэгдсэн байдлаар улирал тус бүрээр эхний сарын 30-ны өдрийн дотор, жилээр гаргах **аналитик** тайланг тайлан тус бүрт тусгасан үзүүлэлт бүрээр гаргаж дараа жилийн эхний улиралд багтаан ирүүлнэ.
- 6.3 Мониторингийн дүнгээр хүргүүлэх албан тоот, график, чарт хэлбэрийн тайланг сар бүр ирүүлэх тайлангийн хамт дараа сарын 10-ны дотор, электрон хэлбэрээр гаргаж ирүүлнэ.
- 6.4 Ажлын даалгаварын 4-р зүйлд заасан хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр нэвтрүүлэг эхэлсэн дууссан үргэлжилсэн хугацааг цаг:мин:сек-р гаргах, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, нэмэлт тайлбар, хөтөлбөрт эзлэх хувь хэмжээ, 1 хоног, 7 хоног, сараар нэгтгэсэн дэлгэрэнгүй, хураангуй байдлаар шаталсан тайлан гаргах;
- 6.5 Хяналт, мониторингийн үзүүлэлт тус бүрээр шаталсан дэлгэрэнгүй, хураангуй тайлан гаргах;
- 6.6 Мониторингийн сар бүрийн дүнг үйлчилгээ эрхлэгч тус бүрээр мониторингийн дүнг хүргүүлэх загварт оруулан програм хангамжийн тусламжтайгаар автоматжуулан гаргаж ирүүлнэ.

7. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ УДИРДАМЖ

- 7.1 Хяналт, мониторингийн өдөр тутмын тайлан мэдээг долоо хоног, сараар нэгтгэн гаргаж захиалагч талд электрон хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 7.2 Тайлан ирүүлэхдээ тайлангийн хугацаанд хамрагдсан телевизүүдийн тоо, үүнд шинээр нэмэгдсэн эсвэл хяналт, мониторингд хамрагдаагүй бол хамрагдаагүй шалтгаан зэргийг тайлбарласан товч тайлбар, тайлан, нотломжийг хамт ирүүлнэ.
- 7.3 тайлангийн бүтэц, аргачлалын дагуу тайланг нэгтгэж, дүгнэлт гаргахад ойлгомжтой, ирүүлсэн тайлан, мэдээг шууд ашиглах боломжтой, дахин боловсруулалт хийх шаардлагагүй, хялбар байдлаар ирүүлнэ.
- 7.4 Мониторингийн сар бүрийн дүнг, үзүүлэлтийг програмын тусламжтай форматын дагуу автоматаар график, чарт хэлбэрт оруулан ирүүлнэ.
- 7.5 Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд тухайн телевизийн эфирийн бичлэгээс холбогдох нэвтрүүлгийн тодорхой цагийн бичлэгийг ирүүлнэ.
- 7.6 Тодорхой хугацааны дараа бичлэг устахаас өмнө Захиалагчид энэ талаар албажуулан албан тоотоор мэдэгдэж саналыг нь авсан байна.
- 7.7 Телевизийн нэр, үйлчилгээний нэр өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар Захиалагч байгууллагад шуурхай мэдэгдэж тодруулга авна. Долоо хоногт 1 удаа хайлт хийж жагсаалтад шинээр нэмэгдсэн болон хасагдсан телевизийн талаарх мэдээллийг Захиалагч байгууллагад шуурхай гаргаж өгнө.
- 7.8 Захиалагчаас шаардсаны дагуу холбогдох эфирийн дүрс, бичлэг, хөтөлбөрийн баримт, нотолгоог шуурхай гаргаж ирүүлнэ.
- 7.9 Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээ, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх.
- 7.10 Гүйцэтгэгчийн хяналтын ажилтан өдөр бүрийн тайланг нэгтгэн дараа сарын эхэнд програмын аргаар датабаазаас Excel хэлбэрээр тайлангуудыг гаргаж, Захиалагчид и-мэйлээр илгээнэ. Тайлан бүрийг дэлгэрэнгүй болон хураангуй 2 хэлбэрээр гаргах ба

нийт тайланг CD–д бичиж баталгаажуулан захиалагчид нэхэмжлэхийн хамт биечлэн хүргүүлнэ.

- 7.11 Жилийн эцсийн аналитик тайланг гаргахдаа урьдчилан Захиалагчтай уулзаж, зөвлөгөө авах, энэхүү ажлын даалгаварт заасан тайлангийн үзүүлэлт тус бүрийг нэгтгэн, аналитик дүгнэлт гаргаж нэгдсэн тайлан ирүүлнэ.

8. АЖЛЫН ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭХЭД ТАВИГДАХ ШАЛГУУР ШААРДЛАГА

8.1 Ерөнхий шаардлага

- Хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд гүйцэтгэгч этгээд нь компанийн тухай хуулийн 6.14-т заасан /нэг/ нэгдлийн оролцогчид биш байна.
- Гүйцэтгэгч
- нь хорооноос олгодог өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч бус байх, гүйцэтгэх удирдлагын хувьд сүүлийн 3 жил аль нэг өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллаагүй байна.

8.2 Техник хангамж, ажлын туршлага, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн хувьд тавигдах шалгуур

Энэхүү ажил нь өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу шат дараатай арга хэмжээ авах үндэслэл шалтгаан болох бөгөөд шат дараатай арга хэмжээнд зөрчлийн талаар мэдэгдэх, сануулга өгөх, зөрчлийг арилгах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах, тусгай зөвшөөрлийг сунгах эсэх талаар дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ хамаарах тул хянуур нямбай ажиллаж, үнэн зөв алдаагүй тайлан гаргах, эфирийн дэлгэрэнгүй протокол, тайлан зөрүүгүй байх талаар анхаарч ажиллана. Энэхүү ажлын даалгаврыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гэрээлэгч нь дараах нөөц боломж, чадвар, мэдлэг, туршлагыг хангах боломжтой байна. Үүнд:

- Энэхүү ажлын даалгаврын 3-р зүйл. Хяналт, мониторингийн хамрах хүрээнд заагдсан тооны телевизийн хөтөлбөрт нэгэн зэрэг, байнгын хяналт, мониторинг хийх техникийн болон ажиллах хүчний чадавхийг бүрдүүлэх боломжтой байх.
- Дээрх тооны телевизүүдийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийх, эфирийн бичлэг хийх, хадгалах бүрэн хүчин чадал бүхий сервер, архивын техник төхөөрөмж, систем, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Мониторингд хамрагдсан бүх телевизийн эфирийн бичлэгийг 3 сар хадгалах серверийн тоног төхөөрөмж, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Телевизийн сигналыг хүлээн авах техникийн шийдэл, нөөц шийдэл, ОСДҮЭ-ээс сигнал хүлээн авч байгаа тохиолдолд аль болох олон ОСДҮЭ-ийн сигналыг хүлээн авах боломжтой байх.
- Цахилгааны доголдолоос хамааралгүйгээр хяналт, мониторинг хийх, эфирийг найдвартай тасралтгүй бичих, хэвийн ажиллагааг хангах цахилгааны нөөц зэрэг шийдлийг бүрдүүлэх боломжтой байх.
- Дата мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох харьцуулалт, судалгаа, дүн, мэдээ, тайлан, эфирийн бичлэгийг тухайн сар, өдөр, цаг

минутаар түргэн шуурхай гаргах техник, технологи, програм хангамжийн боломжийг бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байх.

- Хяналт, мониторингийн үйлчилгээг хийх аргачлал, хяналт, мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийг гаргах, хяналт, мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах чадавхитай байх.
- Гүйцэтгэгчийн ирүүлэх үнийн санал нь өртөгт суурилсан байх бөгөөд үнийн саналын үндэслэл, тооцоог дэлгэрэнгүй байдлаар гаргаж тайлбартай ирүүлнэ. Мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийн дагуу нэг ажилтанд ногдох эфирийн цаг, телевиз, сувгийн тоо, мониторингийн үзүүлэлт, тухайн ажилтны ажил үүрэгт ажлын даалгаварт өгөгдсөн ажлын эзлэх хувь, хэмжээ, ажлын ачаалал, зардлын тооцоо, төсвийг гаргаж үндэслэсэн байх.
- Холбогдох журам, тавигдах шаардлага, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад өөрчлөлт орж хяналт, мониторинг хийх үзүүлэлт өөрчлөгдөх, нэмэлт оруулах тохиолдолд өөрчлөлтийг түргэн шуурхай хийх нөхцөлийг бүрдүүлсэн байх.
- Датабааз, файлын сан, програм хангамж, мэдээллийг цахим халдлагаас хамгаалах мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системийн шийдлийг бүрдүүлсэн байх.
- Урьдчилгаа төлбөр авалгүйгээр “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжтай байх.

8.3 Гүйцэтгэгч нь хамгийн багадаа дараах хүснэгтэд тусгасан шаардлагатай мэдлэг чадвар, туршлагатай боловсон хүчнээс бүрдсэн баг санал болгох ба гэрээнд заасан ажил үүргийг заасан хугацаанд гүйцэтгэх чадвартай байна.

Албан тушаал	Чиг үүрэг	Ажлын туршлага
Багийн ахлагч	Ажлыг удирдан зохион байгуулах, гэрээлэгчийг төлөөлж захиалагчтай харилцах	<ul style="list-style-type: none"> • Судалгааны ажил, төсөл, багийн ажиллагаанд оролцож ажиллаж байсан туршлагатай байх • Судалгаа, шинжилгээ, статистик буюу холбогдох чиглэлээр зэрэг цолтой бол давуу тал болно
Хяналтын ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээний бүтэц, загварыг боловсруулах, хяналт, мониторингийн явцад хяналт тавих	<ul style="list-style-type: none"> • Статистик, судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай • Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай • Мэдээ, тайланг алдаагүй, нягт нямбай гаргах чадвартай
Програм хангамж хариуцсан ажилтан	Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх	<ul style="list-style-type: none"> • Програм хангамжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх • Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх • Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх чадвартай байх
Техник, ашиглалт хариуцсан ажилтан	Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлээрээ л ажилласан туршлагатай байх • Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх • Техник төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хийх, техникийн өргөтгөл хийх чадвартай байх • Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх

Статистик судалгааны ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээнд анализ, шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> • Статистик , судалгаа шинжилгээний чиглэлээр боловсрол эзэмшсэн • Дээд боловсролтой • Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай байх
Мониторингийн ажилтан	Бүртгэл хийх, тайлан бэлдэх	<ul style="list-style-type: none"> • Их хэмжээний мэдээллийн баазтай ажиллах чадвартай

9. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ БА АЖЛЫН ХУВААРЬ

Гүйцэтгэгч нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах арга зүй, үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, тендерийн баримт бичгийн маягт 5, маягт 6-ийн дагуу гаргаж ирүүлэх. Энэхүү үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө болон үүнтэй ижил төстэй даалгаврыг ямар хугацаа, техникийн туслалцаа, ажлын бүтэц бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байсан туршлагын баримтжуулалтыг хавсаргана.

10. МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗАГВАР

Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын чиглэлээр

1. Эфирийн тухайн сарын өдөр бүрийн (06:00-01:00) протокол; Эфирийн өдрийн протокол нь огноо, тухайн нэвтрүүлэг эсвэл зар сурталчилгаа эхэлсэн, дууссан хугацаа, үргэлжилсэн хугацаа, нэр, төрөл, жанр, тайлбар зэрэг бүх л мэдээллийг агуулсан өдөр бүрийн дэлгэрэнгүй протокол байна;
2. 7 хоногийн хөтөлбөрт эзлэх **үндэсний бүтээлийн** (Өргөн нэвтрүүлгийн телевизийн 7 хоногийн нийт хөтөлбөрийн 60%-иас доошгүй, арилжааны телевизийн 7 хоногийн нийт хөтөлбөрийн 50%-иас доошгүй байх) шаардлага хангасан тайлан; Тайланд нэвтрүүлэг эхэлсэн дууссан хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл, жанр, дотоод, гадаад болох тайлбар, 7 хоногийн эцэст хөтөлбөрийн нийт цагийг цаг:мин:сек-р гаргах, үндэсний бүтээлийн нийт цаг, эзлэх хувийг агуулсан байна.
 - 2.1. Үндэсний бүтээл, гадаад нэвтрүүлгийн талаарх тайлан гаргахдаа гадаад хэл дээрх нэвтрүүлгийг дуу оруулаагүй, хадмал орчуулгагүй гаргасан бол тухайн нэвтрүүлгийн үргэлжилсэн хугацааг тэмдэглэж 7 хоног, сараар дүнг нэгтгэнэ. Хөтөлбөрийн бүтцэд гадаад нэвтрүүлгийн эзлэх хэмжээ, хувийг гаргаж, 7 хоног, сарын хөтөлбөрт гадаад нэвтрүүлгийн эзлэж буй хувийг тодорхойлох, гадаад нэвтрүүлгийг нэвтрүүлгийн төрлөөр, жанраар тус тус ангилах;
3. Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагт эзлэх **өөрийн бүтээлийн эзлэх хувь** хэмжээг тодорхойлох, тухайн сарын шинэ дугаар, давталтын тоо зэргийг агуулсан тайлан;
4. Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийн нэг сард нэвтрүүлсэн түүх, соёл, уламжлалын нэвтрүүлгийн бүртгэл, цагаар гаргах; үүнээс шинэ бүтээлийн бүртгэл,

- хөтөлбөрт эзлэх цагаар болон хувиар гаргах; (Жилд нэвтрүүлсэн түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нь 200 цагаас багагүй байх шаардлагыг, үүний 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байх шаардлагыг хангаж байгаа эсэх);
5. Өргөн нэвтрүүлгийн телевизийн жилд нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлэг 180 цагаас багагүй байх шаардлагыг хангаж байгаа эсэх, нэг сард нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн бүртгэл, хөтөлбөрт эзлэх цагаар болон хувиар гаргах, нэвтрүүлгийг бүтээсэн улс орноор гаргах;
 6. Өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийн жилд нэвтрүүлсэн 3+, 6+, 12+ насны ангилалтай нэвтрүүлгийн нийт цагийг насны ангилал тус бүрээр, үргэлжилсэн хугацаа, төрөл жанр, бүтээсэн улс орноор гаргах; (тайланг жилээр нэгтгэн 6+, 12+ насны ангилалтай нэвтрүүлэг жилд 130 цагаас багагүй байх шаардлагыг, үүний 20%-иас доошгүй нь шинэ бүтээл байх шаардлагыг хангаж байгаа эсэх, 3+ насны ангилалтай нэвтрүүлэг нь жилд 90 цагаас багагүй байх шаардлагыг хангасан эсэх)
 7. Телевизээр нэвтрүүлэх гадаадын аль нэг улсын кино нь нэг сарын хөтөлбөрөөр нэвтрүүлэх гадаад киноны шаардлагыг (нийт киноны 50%-иас хэтрэхгүй байх) хангаж байгаа эсэх тухай тайлан;
 8. Телевизээр нэвтрүүлж буй уран сайхны кино, олон ангит кино, хүүхдийн кино, хүүхэлдэйн киног бүтээсэн улс орон, төрөл, жанраар ангилан гаргах, киноны насны ангилал, тэмдэг тэмдэглэгээний үзүүлэлтийг тайланд тусгах (Киноны тайлан)
 9. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизээр дамжуулсан цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлгийг Монгол хэлний дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах заалтын хэрэгжилтийг хангаж байгаа эсэх;
 - 9.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз нь Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын 3.10.2-т заасан хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байх шаардлага хангасан эсэх; (Жич: Арилжааны телевизийн хувьд хүүхдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн хүргэх үүрэг хүлээгээгүй тул, МУ-д хамрах хүрээтэй арилжааны телевизийн хувьд: хэрэв хөтөлбөрт нь хүүхдэд зориулсан нэвтрүүлэгтэй, тэр нь дохионы хэлтэй гарсан бол тэмдэглэнэ
 10. Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг тэмдэглэгээтэй буюу 18+ насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг 06:-22:00-ийн хооронд нэвтрүүлсэн, давтан дамжуулсан зөрчил гаргасан телевиз, сувгуудын зөрчлийн тайланг 7 хоног, сараар нэгтгэж гаргах, дамжуулсан огноо, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбарын хамт гаргана гэх мэт байна.
 - 10.1. Илт зохисгүй агуулга, контент бүхий дүрс бичлэг, кино, нэвтрүүлэг, хөтөлбөрийг бүртгэлжүүлж ирүүлэх, тайлан ирүүлэх
 11. Теле худалдааны төрөлжсөн чиглэлийн телевизийн хөтөлбөр нь теле худалдааны чиглэлээр 100% төрөлжсөн байх заалтын хэрэгжилтийг хангаж байгаа эсэх - Теле

худалдааны чиглэлээр төрөлжсөн сувгуудын тайланг тусад нь гаргаж, ажлын даалгаварт өгсөн үзүүлэлтийн дагуу хийсэн мониторингийн дүнг 7 хоног, сараар нэгтгэж гаргана.

12. Телевизээр дамжуулж байгаа хүүхдийн нэвтрүүлгийн нийт цаг, нэвтрүүлгийн тоо, давталтын дугаар болон шинэ дугаарын цаг, хувь хэмжээ, хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн төрөл, жанраар ангилах, бүтээсэн улс орноор ангилах, хөтөлбөрт эзлэх цагаар гаргах. Дохионы хэл, бичгэн тайлбартай гарсан эсэх; (Хүүхдийн нэвтрүүлгийн тайлан)
13. Төлбөртэй телевиз хянуулах тохиолдолд хөтөлбөрийн төрөлжсөн чиглэлийн хувь хэмжээ; Төлбөртэй сувгийн зөвшөөрөлтэй телевизээр зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх; Төлбөртэй телевизээр бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлтээс бусад зар сурталчилгаа, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, теле худалдааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх;

Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд тавигдах шаардлага – чиглэлээр

1. Телевизийн арилжааны зар сурталчилгааны цацалтын хугацааг үндсэн эфирийн цаг тус бүрээр нь тусад нь гаргасан өдөр бүрийн тайлан, болон хураангуй тайлан; уг тайлан нь эфирийн аль цагт, ямар нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгааны хэтрэлт гарсан, зар сурталчилгааны төрөл, тайлбар, хэтрэлтийн нэгдсэн дүнгагуулсан байна. Зар сурталчилгааны хэтрэлтийг тайлан хүснэгтийн дор 7 хоног, сараар нэгтгэж нийц цагийг гаргана.
2. Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизээр нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, үүнд: “1 цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх” заалтыг хангасан байдал;
3. Оргил цагаар нэвтрүүлэх зар сурталчилгааны 80 хувиас доошгүй нь Монголд бүтээсэн байх заалтыг хангасан байдал;
4. Нийт оргил цаг /18:00-23:00/ болон оргил цагийн нэг цаг тутамд нэвтрүүлж буй зар сурталчилгааны тайлан.
5. Нэг цагт нэвтрүүлж буй зар сурталчилгаанд эзлэх блокын тоо, блокын үргэлжлэх хугацааг тодорхойлох, үүнээс нэг блокны үргэлжлэх хугацаа 5 минутаас хэтэрсэн эсэх, хэтэрсэн блокны тоо;
6. Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
7. Телевизээр хоногт нэвтрүүлсэн арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15%-иас илүүгүй байх заалтыг хангасан эсэх - арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийн үргэжилсэн хугацаа,
8. Мэдээний дундуур зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;

9. Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн багц хооронд 2-оос ихгүй зар сурталчилгааны блок нэвтрүүлэхгүй байх шаардлагыг хангасах эсэх;
10. Телевизээр нэвтрүүлж буй зар сурталчилгааг дотоод болон гадаад бүтээлээр ангилах, дотоод, гадаад сурталчилгааны бүтээлийн хийцээр эзлэх хугацааг тухайн сараар тогтоох;
11. Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй аливаа нэвтрүүлэг, киноны үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр, урсдаг зар байдлаар дэлгэц дээр гаргаж байгаа эсэх;
12. МҮОНТ-ийн хувьд арилжааны зар сурталчилгаа нэвтрүүлсэн байдал, өдрийн хөтөлбөрийн 2 хувиас хэтэрсэн эсэх (улирлаар);
13. "Телевиз нь эд мөнгөний хонжворт сугалаа болон бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр худалдан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй."
14. Балчир насны буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх заалтын хэрэгжилтийг хангасан эсэх;
15. Бага насны буюу 6+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа нь 30 минутын хугацаанд таван минутаас илүүгүй байх заалтыг хэрэгжилтийг хангасан эсэх;
16. Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизээр зар сурталчилгаа, бүтээгдэхүүн байршуулалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөр, захиалгат нэвтрүүлэг, нэвтрүүлсэн эсэх;

Телевизээр дамжуулах зар сурталчилгаанд тавигдах шаардлагатай холбоотой бусад үзүүлэлтүүд

Дараах үзүүлэлтийг сар бүрийн тайлангийн дэлгэрэнгүй протоколоос харах боломжтой байх, мониторингийн дүнг улирлаар нэгтгэж, тайлан ирүүлэх

1. Хүүхдийн нэвтрүүлэг дундуур хүүхдийн сэтгэхүй болон бие махбодод сөргөөр нөлөөлөх дараах хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх
 - Бүх төрлийн хийжүүлсэн ундаа;
 - Энергийн болон спортын ундаа;
 - Бүх төрлийн чанадаг болон дэвтээдэг бэлэн гоймон
2. Телевизийн нэвтрүүлж буй зар сурталчилгаанд эзлэх нийгмийн зар сурталчилгааны хугацааг тогтоох;

3. Телевизийн хоногийн эфирийн нийт цаг болон 1 цагт нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, зар сурталчилгааг нийлүүлэгч, үйл ажиллагааны чиглэл/салбар/-ээр нь ангилан гаргах;
4. Ивээн тэтгэгчтэй нэвтрүүлгийн бүртгэлийг хийх, ивээн тэтгэгчийг тухайн нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд болон нэвтрүүлгийн явцад дурдсан эсэх;
5. Бүтээгдэхүүн байршуулалттай нэвтрүүлгийн бүртгэл;
6. Төлбөртэй эсхүл захиалгатай нэвтрүүлгийн бүртгэл; “Төлбөртэй нэвтрүүлэг” эсхүл “Захиалгат нэвтрүүлэг” гэсэн тэмдэглэгээтэй эсэх;

Нөхцөл, шаардлагаар тавигдах шаардлага – чиглэлээр

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангасан байх заалтын хэрэгжилтийг хангасан эсэхийг тодорхойлох; (Телевизийн хөтөлбөрийн тасалдалтын бүртгэлийг цаг, минут, сек-ээр гаргах, тухайн сард тасалдсан хөтөлбөрийн нийт хугацааг тодорхойлж гаргах, эфирийн тасалдалтын шалтгаан *(шалтгааныг өөрсдийн зүгээс аль болох боломжит байдлаар тодорхойлж, тайлбар бичих)*)
2. ОСДҮЭ-ийн үндсэн багцын гадаад сувгийн жагсаалт, гадаад сувгийн эрхийг эзэмшигч улсын нэр, дамжуулагдаж байгаа хэл, сувгийн хөтөлбөрийн төрөл жанр, чиглэл /өргөн нэвтрүүлгийн телевиз, төрөлжсөн суваг, тухайн улс үндэстний соёл, уламжлалыг бусад улсад сурталчлах зорилго бүхий англи хэл дээрх суваг/; (зөвхөн шаардлагатай тохиолдолд бодит гарч байгаа сувгуудын жагсаалтыг авах)

--oO--

БАГЦ 1**Улаанбаатар хотын Өргөн нэвтрүүлгийн телевизийн жагсаалт**

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	АЭ энд Жааг ХХК	25-р суваг	Монгол Улс
2.	Улаанбаатар телевиз ХХК	UBS	Монгол Улс
3.	Гэгээн далай ХХК	TB5	Монгол Улс
4.	Алсын гэрэл ХХК	TM	Монгол Улс
5.	Супервижн медиа групп ХХК	SBN	Монгол Улс
6.	Суваг ти ви найм ХХК	TV8	Монгол Улс
7.	Чаннел-Уан ХХК	C1	Монгол Улс
8.	Медиа холдинг ХХК	TB9	Монгол Улс
9.	Тэнгэрлэг эх орон ХХК	Central	Монгол Улс
10.	Эн Ти Ви Бродкастинг ХХК	NTV	Монгол Улс
11.	Ийгл Бродкастинг ХХК	Eagle News	Монгол Улс
12.	Монгол телевиз ХХК	Монгол	Монгол Улс
13.	Про медиа нетворк ХХК	TenGer	Монгол Улс
14.	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Star	Монгол Улс
15.	Имерж медиа ХХК	ETV	Монгол Улс
16.	Медиа боловсрол суваг ХХК	суваг	Монгол Улс
17.	Малчин удмын хийморь ХХК	Малчин	Монгол Улс
18.	Улс сүлд ХХК	Сүлд	Монгол Улс
19.	Фило ХХК	TV24	Монгол улс
20.	ТВ дөрөв ХХК	TV4	Монгол улс
21.	Датуком ХХК	BBS TV	Монгол улс

Улаанбаатар хотын Арилжааны телевизийн жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	Мөрөөдлийн суваг ТББ	Dream tv	Монгол Улс
2.	Шууд Ти Ви ХХК	Asar shop	Монгол Улс
3.	Парламентын суваг ХХК	Парламентын суваг	Монгол Улс
4.	Эх гоёот медиа групп ХХК	Channel 11	Монгол Улс

5.	Медиа холдинг ХХК	Синема	Монгол Улс
6.	Өлзий медиа ХХК	Өлзий телевиз	Монгол Улс
7.	Эм Ви Эс ХХК	Мон плас	Улаанбаатар хот
8.	Эйшн бокс ХХК	Asian box	Монгол Улс
9.	Гэгээн далай ХХК	TB5-2	Монгол Улс
10.	Мөүвибокс ХХК	Movie Box	Монгол Улс
11.	Форчун глобал ХХК	Аист Глобал	Монгол Улс
12.	Эн Би Жи Кинг Монголиа ХХК	Нийслэл	Монгол Улс
13.	Эвергрийнлайф ХХК	7-р суваг	Монгол Улс
14.	Эс Си Эйч ХХК	Суваг 1	Монгол Улс
15.	Хатрек ХХК	Eco tv	Монгол Улс
16.	Ханлиг Өлзий ХХК	Скай	Улаанбаатар хот
17.	Модерн Кастл Модифаер ХХК	Соён гэгээрүүлэгч	Монгол Улс
18.	Нэйшнл ньус корпорэйшн ХХК	Bloomberg	Монгол Улс
19.	Ди Ви Продакшн ХХК	TV3	Монгол Улс
20.	Монголиан ньус чаннел ХХК	MNC	Монгол Улс
21.	Гэгээн далай ХХК	Moviemax	Монгол Улс
22.	Дэлхийн чимээ медиа групп ХХК	Live	Монгол Улс
23.	Реал Мастер линкс ХХК	Like	Монгол Улс
24.	Монгол телевиз ХХК	Монгол тв +1	Монгол Улс
25.	Хөгжил телевиз ХХК	Хөгжил	Монгол Улс
26.	Малчин телевиз ХХК	Мянгат малчин	Монгол Улс
27.	Дөрөв кэй мүүв ХХК	Талын Монгол	Монгол Улс
28.	Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК	NTN	Монгол Улс
29.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 1	Монгол Улс
30.	Мюзик бокс ХХК	Хөг-жим	Монгол Улс
31.	Эгон ХХК	ШОП Монголиа	Монгол Улс
32.	Масс Ти Ви ХХК	Масс ТВ	Монгол Улс
33.	Монзах ХХК	ONTV	Монгол Улс
34.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 2	Монгол Улс
35.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 3	Монгол Улс

36.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 4	Монгол Улс
37.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 5	Монгол Улс
38.	Сарны чулуу анар ХХК	TV6	Улаанбаатар хот
39.	Маст технологи ХХК	News channel	Улаанбаатар хот
40.	Буган соёл ХХК	Хөх Монгол	Улаанбаатар хот
41.	Энтертаймент интэрпрайс ХХК	Бидний цөөхөн Монголчууд	Монгол улс
42.	Лакс ТВ Монгол ХХК	Luxe TV	Улаанбаатар хот
43.	Найс ти ви ХХК	АВТО	Улаанбаатар хот
44.	Сичаннель ХХК	Си чаннель	Улаанбаатар хот
45.	Малчин удмын хийморь ХХК	Их засаг	Монгол Улс
46.	Монвсат нэтворк ХХК	Нэгдэл	Улаанбаатар хот
47.	Жи суваг ХХК	Gandan TV	Монгол улс
48.	Эм Ди Энтертэйнмент ХХК	TV2	Монгол улс
49.	Төгс барчин хангай ХХК	Цахим монгол ТВ	Улаанбаатар хот
50.	Трионикс мета вишн ХХК	Попкорн тв	Улаанбаатар хот
51.	Хит-Интертаймент ХХК	HIT	Улаанбаатар хот
52.	Эм Эн Медиа Групп ХХК	MNTV	Улаанбаатар хот
53.	Гангын урсгал ХХК	GU телевиз	Улаанбаатар хот
54.	Байсикл медиа ХХК	BMTV	Улаанбаатар хот

Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-1	Монгол улс

2.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-мэдээ	Монгол улс
3.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-спорт	Монгол улс
4.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-World	Монгол улс
5.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-хүүхэд, гэр бүл	Монгол улс

Төлбөртэй телевизийн жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	Контент дистрибьюшн ХХК	UniSport 1	Монгол улс
2.	Контент дистрибьюшн ХХК	UniSport 2	Монгол улс
3.	Номадиа нэтворк ХХК	Монгол кино	Монгол улс
4.	Номадиа нэтворк ХХК	Монгол цуврал	Монгол улс
5.	Номадиа нэтворк ХХК	Шинэ кино	Монгол улс
6.	Монвсат нэтворк ХХК	Төлбөрт үзэлт 900	Монгол улс
7.	Монвсат нэтворк ХХК	Шилдэг кино 996	Монгол улс
8.	Монвсат нэтворк ХХК	Монгол кино 997	Монгол улс
9.	Монвсат нэтворк ХХК	Ази кино 998	Монгол улс
10.	Монвсат нэтворк ХХК	Тв театр 999	Монгол улс
11.	Маст технологи ХХК	900 Кино	Монгол улс
12.	Маст технологи ХХК	902 Kids	Монгол улс
13.	Маст технологи ХХК	903 HITS	Монгол улс
14.	Скайтел ХХК	MN+	Монгол улс
15.	Номадиа нэтворк ХХК	DDISHMUSIC	Монгол улс
16.	Монвсат нэтворк ХХК	ТВ театр 995	Монгол улс
17.	Скайтел ХХК	Sky live	Монгол улс
18.	Номадиа нэтворк ХХК	Ddsih live	Монгол улс
19.	Юпланэт ХХК	Юнилайв 88	Монгол улс
20.	Монвсат нэтворк ХХК	Тв театр 994	Монгол улс
21.	Мөүви бокс плас ХХК	Moviebox Plus	Монгол улс